



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 4/47

Арвайхээр сум

Өмч хамгаалах зөвлөл шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Монгол улсын төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолын 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Өмч хамгаалах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга: Т.Бадамхорол (Татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга: Б.Бямбасүрэн (Хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагч)

Гишүүд: Л.Буянжаргал (Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч)

Д.Болор-Эрдэнэ (Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн Татварын улсын байцаагч)

Я.Чойсүрэн (Жолооч-слесарь)

3. Байгууллагын үндсэн хөрөнгийг актлах, шилжүүлэх, устгахад дээрх журмыг баримтлахыг өмч хамгаалах зөвлөлийн дарга (Т.Бадамхорол)-д үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/30 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Н.ЭРДЭНЭСУВД



621001093